



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 03 өдөр

Дугаар 172

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дорнод аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 33,000,000.00 (гучин гурван сая) төгрөгийн балансын үнэ, 17,527,726.90 (арван долоон сая таван зуун хорин долоон мянга долоон зуун хорин зургаан төгрөг ерэн мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий УАЗ-220695 маркийн 8131 ДОО улсын дугаартай автомашиныг Дорнод аймгийн Мал эмнэлгийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Дорнод аймгийн Мал эмнэлгийн газрын дарга Ч.Аюушмаад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем”-д бүртгэх;

2.3.Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД



132000552
8-r huraldaan.docx